



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/02

Хэрлэн сум

**Цэргийн штабын бэлэн байдлыг
дээшлүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/03 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цэргийн штабын албан үүргээ биелүүлэх нөхцөлийг сайжруулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цэргийн дүйцүүлэх албан хаагчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр хангах, сургалт дадлага явуулахад шаардлагатай материал хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай 46,409,500 (дөчин зургаан сая дөрвөн зуун есөн мянга таван зуун) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн бэлтгэл сургууль, цугларалт, зориулалтын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

А.ЖАРГАЛСАЙХАН

